

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 28-НЫ  
ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИТХ-ЫН ДАРГА Д.БАТТУЛГА, НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Э.БАТ-ҮҮЛ НАРЫН ӨГСӨН  
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

2013.11.11

**НЭГ.** Нийслэлийн 2013 оны төсвийн тодотголыг нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд 2013 оны 11 дүгээр сарын 01-нд багтаан, 2014 оны төсвийг хуулийн хугацаанд буюу 2013 оны 11 дүгээр сарын 25-ны дотор НИТХ-д тус тус өргөн барих.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа нийслэлийн 2013 оны төсвийн тодотголын тухай асуудлыг хэлэлцүүлсэн ба тодотголыг 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр нийслэлийн ИТХ-д өргөн барьсан.

Нийслэлийн 2014 оны төсвийн төслийг иргэдээр хэлэлцүүлж, санал авах ажиллагаа явагдаж байна. 2014 оны төсвийг хуулийн хугацаанд өргөн барих бэлтгэл хангагдсан болно.

Нийслэлийн 2014 оны төсөв батлагдсаны дараа дүүргийн Засаг дарга нар дүүргийн 2014 оны төсвөө дүүргийн ИТХ-даа 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор өргөн мэдүүлэх, дүүргийн ИТХ-даанаар 12 дугаар сарын 20-ны дотор батлахаар хуульчлагдсан байдаг.

**ХОЁР.** Төсвийн 2013 оны тодотголд Налайх дүүргийн дулааны гол шугамыг солих хөрөнгийг төлөвлөн оруулахын гадна УИХ-аар нийслэлийн 2013 оны төсөв хасагдан батлагдсантай холбогдуулж энэ онд аль ажилд нь хөрөнгө авч үлдэх, аль ажлыг буцаах буюу зогсоох саналаа тавих.

**БИЕЛЭЛТ:** Налайх дүүргийн дулааны гол шугамыг солиход нийслэлийн төсвөөс 36,4 сая төгрөгийг өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд шийдвэрлэсэн. Харин дүүргийн Цэвэр усны станцаас Налайхын дулааны станц хүртэлх цэвэр усны төв шугамаас усны алдагдал байнга гарч байгааг засварлахад шаардлагатай 25.0 сая төгрөг одоогийн байдлаар нийслэлийн 2013 оны төсвийн тодотголын төсөлд тусгагдаагүй байна.

Нийслэлийн хэмжээнд энэ онд хөрөнгө оруулалтаар хийх болон хойшлуулах ажлын талаар нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа холбогдох албан тушаалтнуудтай ярилцан, хуралдаанд танилцуулах саналыг бэлтгүүлээ.

Нийслэлд хэрэгжүүлж буй улсын төсвөөс санхүүжихээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсан ажлын хөрөнгө нь Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголын төслөөр татагдсан асуудлыг дээд шатны байгууллагуудад тавьснаар он дамжин хэрэгжих 2 авто замын хөрөнгийг төсөвт буцаан тусгасан, үлдсэн хөрөнгийг 2014 оны төсөвт тусгуулахаар Эдийн Засгийн хөгжлийн сайд, УИХ-ын Төсвийн байнгын хороонд хандаад байна.

**ГУРАВ.** Хотын хэмжээнд эрчим хүчний асуудал хүндрэлтэй байгааг өнөөдөр Эрчим хүчний сайдтай ярилцахад нийслэлийн Засаг даргын Зам, тээвэр, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч Н.Гантөмөр, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Б.Бадрал нар байлцаж асуудлаа танилцуулах.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулга, нийслэлийн Засаг даргын орлогч Н.Гантөмөр, Улаанбаатар хотын Ерөнхий менежер Б.Бадрал нар Эрчим хүчний болон Эдийн засгийн хөгжлийн сайд нартай уулзаж

ярилцаад “Их тойруу” цахилгааны сүлжээний төслийн үлдэгдэл 19.0 тэрбум төгрөгийг 2014 оны улсын төсвийн төсөлд тусгуулахаар болсны дээр цахилгаан, дулааны 1МВт, 1Г/кал-аас өндөр техникийн нөхцлөөр хангах асуудлыг Эрчим хүчний яам хариуцахаар тохиролцсон байна.

**ДӨРӨВ.** Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба дулаан, цахилгаан, хэрэглээний халуун, хүйтэн усны хангалтын мэдээг өдөр тутам нэгтгэн авч хотын удирдлагад танилцуулах, Улаанбаатар хотын Ерөнхий менежер тушаал гаргаж инженерийн шугам сүлжээ бүхий харъяа байгууллагуудаа бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллуулах.

**БИЕЛЭЛТ:** Захирагчийн ажлын алба инженерийн шугам сүлжээ бүхий харъяа байгууллагууддаа өдөр тутмын мэдээ ирүүлж байх талаар мэдэгдсэн ба эхний удаад 7 хоногоор мэдээг авч нөхцөл байдалд дүгнэлт хийсэн.

Цаашид цахилгаан, халуун, хүйтэн усны хангамж, нийтийн тээврийн үйлчилгээ зэргээр дэлгэрэнгүй мэдээ авч нэгтгэн танилцуулах, мөрөөр нь ажиллах ажлыг хэрхэн оновчтой, хялбаршуулан зохион байгуулах талаар судалж байна.

**ТАВ.** Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар нийслэлийн Аудитын явцын дүгнэлтийг хэлэлцсэнтэй холбогдуулан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, төсөвт газрууд бүтэц, орон тоо /давхардал/, байгууллагын үйл ажиллагааны одоогийн менежментээ авч үзэж хянах, захиргааны төсвийг хямдруулах арга замуудыг тодорхойлон нийслэлийн Засаг даргын салбар хариуцсан орлогчдод 2013 оны 11 дүгээр сарын 05-ны дотор танилцуулсан байх.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн 2014 оны төсөв боловсруулахтай холбогдуулж нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс дүүргийн ЗДТГ, нийслэлийн төсөвт болон өмчит байгууллага, агентлаг, харъяа газруудын бүтэц, орон тоо, төсөв, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтын талаар санал авахад одоогийн бүтэц, орон тоогоор ажиллах санал ирүүлсэн учир тус хэлтсээс нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн урсгал зардлыг хэмнэх, бүх шатны төсвийн байгууллагын төрийн албан хаагчдын орон тоог цаашид нэмэгдүүлэхгүй байх, орон тоог цөөрүүлж ачааллыг тэнцвэржүүлэх тухай нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж байна.

**ЗУРГАА.** Захирагчийн ажлын алба, дүүргийн ЗДТГ нийслэлийн 374 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд “Их хотын-Их хямдрал” арга хэмжээг зохион байгуулах.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүргийн ЗДТГ-ууд нийслэлийн Засаг даргын “Урамтай урамшуулал, хэмнэлттэй хямдрал” сэдэвт уриалгыг хүлээн авч нутаг дэвсгэрийнхээ үндэсний томоохон үйлдвэрлэгч, импортлогч, худалдаа, үйлчилгээ эрхлэгч 100 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулан Жуковын хөшөө, Яармаг худалдааны төв, Дүүхээ-2 төв, Байгаль эх цогцолбор зэрэг нэр бүхий 148 цэгт хямдралтай болон үнэ буулаа логотой, урамшуулалтай, хонжвортой, сугалаатай үйлчилгээ гарган нийт 180.0 гаруй мянган иргэнд үйлчилсэн байна.

Аж ахуйн нэгжүүд асрамжийн газрын болон асрамжид байнга байдаг хүүхдүүдэд мөнгөн дүнд шилжүүлвэл 20.0 гаруй сая төгрөгийн тоглоом, 20 хүүхэд тус бүрт 500.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй хадгаламжийн дэвтэр, зам талбайн үйлчлүүлэгчдэд 454 ажлын бээлий, 9 нэхий хантааз, 6 өвлийн гутал, хүнсний бүтээгдэхүүний иж бүрдэл 125-ыг тус тус бэлэглэжээ.

Дээрх арга хэмжээнүүдэд нийгмийн хариуцлагаа ухамсарлан идэвхитэй оролцож бусдыгаа манлайлсан 10 аж ахуйн нэгжид нийслэлийн ЗДТГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өргөмжлөл, 36 байгууллагад талархал гардуулсан байна.

**ДОЛОО.** Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа нийслэлийн өмч хөрөнгө, эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан байгууллагуудын /Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Өмчийн харилцааны газар, Эдийн засгийн хөгжлийн газар, Татварын газар зэрэг/ хамтарсан уулзалт зохион байгуулж он дамжсаар ирсэн өр, авлагуудын асуудлыг шийдвэрлэх.

**БИЕЛЭЛТ:** Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нийтийн аж ахуйг сайжруулах төслүүдийн урт хугацаат зээлийг барагдуулах асуудлаар Ус сувгийн удирдах газар, Орон сууц, нийтийн аж ахуйн газар, Автобус нэг, Автобус гурав Цахилгаан тээвэр зэрэг нийслэлийн өмчит байгууллагуудын удирдлагууд, нийслэлийн Өмчийн харилцааны газрын дээрх газруудыг хариуцсан болон Сангийн яамны Өрийн удирдлагын газрын мэргэжилтнүүдийн хамтарсан уулзалтыг нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэж байна.

Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газар нийслэлийн өрийг барагдуулах, эдийн засгийг эрүүлжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн санхүүгийн тайлан, санхүүгийн байдлын тайланд илэрхийлсэн урт хугацаатай зээлийн өрийн талаарх зэрэг бүхий л мэдээллийг авч тусгасны үндсэнд Олон улсын зээлжих эрхийн үнэлгээ тогтоолгох зорилгоор Дэлхийн банктэй хамтран хотын төсөв, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, судалгаа гаргасан байна.

Нийслэлийн Татварын газар татварын орлого бүрдүүлэх, татварын өр барагдуулах ажлыг 2013 оны эхний 10 сарын байдлаар стандарт түвшинд явуулжээ.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар түрээслэгч байгууллагуудын он дамжсан түрээсийн өр 51,9 сая төгрөгийг энэ онд барагдуулсан ба 2013 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар газрын төлбөрийн орлогоос 22,4 тэрбум төгрөг /61.5 хувийн төлөлттэй/, дуудлага худалдааны анхны үнэ 15,9 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна.

**НАЙМ.** Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс хамтран нийслэлийн нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад шаталсан сургалт явуулж, санхүү нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг 2013 оны 11 дүгээр сард багтаан авах. Шалгалтад тэнцээгүй ажилтнуудын ажлын байранд шалгаруулалт явуулах.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдөр нийслэлийн нутгийн захиргааны болон төсөвт байгууллагын санхүүгийн 47 албан хаагчийг хамруулан улсын секторын нягтлан бодох бүртгэлийн сургалт зохион байгуулж, сургалтын дараа санхүү нягтлан бодох бүртгэлийн болон түүнтэй холбогдох хууль, эрх зүйн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авсан байна.

Цаашид ямар сургалт зохион байгуулах хэрэгцээг тодорхойлон судалгаа авсны үндсэнд нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, дүүргийн ЗДТГ-ууд Сангийн яам болон Монголын Мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн институттэй хамтран төсөвт байгууллагын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнууд, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч зэрэг төсвийн шууд захирагч нарт шаталсан сургалтыг /УСНББОУС-ын талаар болон Хууль, эрх зүйн/ энэ сард багтаан явуулж, мэргэшлийн түвшинг тогтоохоор бэлтгэж байна.

Нийслэлийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Монгол Улсын Төсвийн тухай зэрэг хуулиудыг багтаасан төсвийн шалгалтын асуулгуудыг шинэчиллээ.

**ЕС.** Нийслэлийн ЗДТГ "Иргэний оролцоотой төсөв- 2014" аяныг хороодод

зохион байгуулах ажлын хэсэг байгуулах, хорооны иргэдээс төсвийн талаар санал авах.

**БИЕЛЭЛТ:** “Иргэний оролцоотой төсөв- 2014” хэлэлцүүлэг зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 01-ний А/984 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу 2013 оны 11 дүгээр сарын 05-наас 13-ны өдрүүдэд хэлэлцүүлгийг нийслэлийн бүх хороодод зохион байгуулж байгаа талаар хэлэлцүүлгийг зохион байгуулах нийслэлийн төв штабын нарийн бичгийн дарга, нийслэлийн ЗДТГ-ын дарга Ё.Гэрэлчулуун танилцуулга хийнэ.

**АРАВ.** Нийслэлийн ЗДТГ тэргүүний жагсаалч анги, хамт олон шалгаруулах “Монгол цэргийн жавхаа- 2014” уралдааныг зохион байгуулах төлөвлөгөө гарган батлуулж ажиллах.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб “Монгол цэргийн жавхаа-2014” уралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүлээр батлуулан ажиллаж байна.

**АРВАН НЭГ.** Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааны дагуу хийгдэж буй тендер, худалдан авалтын ажлын явцын талаар нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Ю.Идэрцогт, байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл хангалтын талаар Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн гүйцэтгэх захирал Д.Энхсайхан нар нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

**БИЕЛЭЛТ:** Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааны дагуу хийгдэж буй тендер, худалдан авалтын ажлын явцын талаар нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Ю.Идэрцогт нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаад, байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл хангалтын талаар Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн гүйцэтгэх захирал Д.Энхсайхан Захирагчийн ажлын албаны удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанд тус тус танилцуулсан байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС